



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 03 өдөр

Дугаар A/14

Мандалговь

**“Хүүхдийнхээ төлөө бурууг бүү түгээ аяныг”
сурталчлах ажлыг зохион байгуулах тухай**

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 270 дугаар тогтоолоор батлагдсан Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн 3.2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүүхдийнхээ төлөө бурууг бүү түгээ” аяныг 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрөөс 2 дугаар сарын 24-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.
2. Аяныг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Аяны үйл ажиллагаанд шаардагдах 495000 (Дөрвөн зуун ерин таван мянга) төгрөгийн зардлыг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ш.Эрдэнэсүвд), гишүүдэд үүрэг болгосугай.
5. Үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж үр дүнг 2020 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн дотор даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ш.Эрдэнэсүвд)-д даалгасугай.

ДАРГА



Ц. ГАНЗОРИГ

4811900